

АНХ ДЭГДЭЭР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жигдээ

№ 94 (2388)

1974 оны 11 дүгээр сарын 14

ПҮРЭВ

МАЛ ТООЛЛОГОТ САЙН БЭЛДЬЕ

Манай орон даяар жил бүрийн 12 дугаар сарын 15-наас эхлэн явагддаг мал, ХАА-н бусад тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого нь тухайн жилд мал аж ахуйг хөгжүүлж түүний материаллаг баазыг бэхжүүлэх талаар олсон амжилт бүтээлийг нэгтгэн дүгнэж цаашид авах арга хэмжээг төлөвлөхөд улс төр, эдийн засгийн чухал ач холбогдолтой билээ.

Мал тооллогын дүн нь манай малчид, ХАА-н байгууллагуудаас БНМАУ-ыг тунхагласны түүхт 50 жилийн ойг угтаж өрнүүлсэн их ажлын үр дүнг тодорхойлохын хамт 1974 оны мал өсгөх, түүний материаллаг баазыг бэхжүүлэх талаар өгөгдсөн улсын төлөвлөгөөний үзүүлэлтийг дүгнэхэд чухал тулгуур материал болно. Тооллогын ажил түргэн шуурхай үнэн зөв болох нь тооллогын бэлтгэл ажлаас ихээхэн шалтгаална. Тооллогын бэлтгэл ажлын үед өрх, хүн амын шилжилт, малын хөдөлгөөнийг дуусгаж, айл өрхийн жагсаалтыг гарган урьд оны малыг нь нөхөх, нийгмийн малын орлого, зарлагын акт, баримтыг бүрдүүлэн малчидтай урьдчилан тооцоо хийх, хашаа, худаг, тэжээлийн акт баримтыг цэгцлэх, мал тоолох ажлын улс төр, эдийн засгийн ач холбогдолыг хөдөлмөрчдөд өргөн сурталчлах зэрэг ажлууд хийгдэх ёстой.

Мал, ХАА-н бусад тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогот бэлтгэх 45 хоногийн төлөвлөгөө гарган ажиллаж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1972 онд гаргасан 93, 1966 онд гаргасан 398 дугаар тогтоолуудын заалтыг ширхэгчилэн биелүүлж тооллогын ажлыг бэлтгэл зохион байгуулалт сайтай богино хугацаанд явуулах сум-нэгдэл, САА-нууд олширсоор байгаагийн дотор 1973 оны жилийн эцсийн тооллогыг Угтаалцайдам, Баянжаргалан, Борнуур сумд богино хугацаанд чанартай явуулав.

Гэтэл зарим сумдад тооллогын бэлтгэлийг хангалтгүй хийж уг ажилд нийтийн хүчийг сайн зохион байгуулж оролцуулаагүй, айл өрхийг завсардуулах, малчидтай хийх тооцоо болон хашаа, худаг, тэжээлийн акт баримтыг бүрдүүлж бэлэн болгоогүй, тооллогын данс, бүртгэлийг нягтлан бодохын тайлан балансаас зөрүүлэх зэрэг дутагдал гарч байв.

Тэрчлэн тоолоод ирсэнийхээ дараа нэгтгэн товчоолоход данс бүртгэлээ удаашруулах, буруу зөрүү бичих, хугацаа алдаж аймаг орны нэгтгэлийг саатуулах зэрэг дутагдал өнгөрсөн онд Эрдэнэ суманд гарч байлаа.

Ялангуяа хүн, малын шилжилтийн хөдөлгөөн ихтэй Алтанбулаг, Сэргэлэн, Баянцогт, Батсүмбэр, Баянүрх зэрэг сумдад тооллогын бэлтгэл ажлыг эртнээс анхаарч өөрийн сумын нутагт байгаа мал бүхий иргэдийг шилжүүлэн авах эсэх асуудлыг шийдвэрлэхийн гадна тооллого эхлэх жилийн зааг, цаг хугацааг нарийн тогтоосон байх хэрэгтэй.

Мал, ХАА-н тэжээвэр амьтадын тооллогыг улс, орон даяар нэгэн зэрэг эхлэж статистикийн төв газраас батлагдсан маягт зааврын дагуу нүд үзэн үүлс угсаа, нас, хүйсээр нь ялгаварлан тоолж бүртгэдэг учраас тооллогын комисст хариуцлага, чадвартай, үнэнч шударга хүмүүсийг оролцуулах ёстой.

ХАА-н нэгдэл, САА бүр жилийн эцсийн тайлан балансын үндсэн материал болох мал, хөрөнгийн тооллогыг богино хугацаанд чанартай явуулахад санхүүгийн аппаратын хүчийг бүрэн чиглүүлж, суурь малчидтай урьдчилан тооцоо хийж тооцох, бүртгэх ажлаа шуурхай гүйцэтгэх хэрэгтэй.

Тооллогын үед нам, төрийн хяналтанд туслах олон нийтийн байгууллагуудын харуул постуудыг ажилдуулж нэгч малыг орхигдуулалгүй нүд үзэн тоолох, хашаа, худаг, тэжээлийг зааврын дагуу хэмжин тоолох зарчмыг хатуу мөрдөөл зохино.

1974 онд мал аж ахуйн талаар олсон ололт амжилтыг тодорхойлох, 1975 оны төлөвлөгөө зохиох тулгуур болсон жилийн эцсийн мал тооллогын ажлыг үнэн зөв, шуурхай явуулахын тулд ХАА-н байгууллагууд одооноос эхлэн тооллогын бэлтгэл ажлыг хангах талаар тодорхой төлөвлөгөө зохион ажиллах хэрэгтэй.

Цахилгаан утас солилцов

Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Аюуа, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч.Дашдэмбэрэл нар Зөвлөлт Курган мужийн хөдөлмөрчдөд Октябрийн социалист хувьсгалын 57 жилийн ойг тохиолдуулан тус аймгийн хөдөлмөрчдийн өмнөөс халуун баяр хүргэж, коммунист байгууламтаандаа улам их амжилт олохыг хүсн эрөөсөн баярын цахилгаан утас илгээсэнд Курган мужийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ф.К.Князев, мужийн Гүйцэтгэх хорооны дарга А.И.Махнев нар хатуу цахилгаан утас ирүүлж, уг цахилгаан утсанд тус аймгийн хөдөлмөрчдөд баярын мэндчилгээ дэвшүүлж, МАХН-ын III их хурал хуралдсан, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтсан социалист уралдаандаа улам их амжилт олохыг хүсн эрөөжээ.

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНЫ АЙЛЧЛАЛД

Шинэ уран бүтээлээр бэлэг барина

Аймгийн Соёлын ордноос хүмүүс гэрийн зүг харьж явахдаа «Эрүү цагаан болжмор» гэдэг дуулалт жүжиг үнэхээр сайхан болжээ гэж хоорондоо ярилцан явахыг сонсоод Соёлын ордны найруулагч Г.Чимэдтэй уулзав. Тэр:

—Манай Соёлын ордны уран бүтээлчид энэ оны 10 сарын хугацаанд «Төрийн алдар», «Ардын дууны цоморлиг», «Намын жоолодлогоор», «Эхийн дуу», «Найрамдын дуу» зэрэг концерт, жүжиг 10 гаруйг найруулан тоглолоо. Тоглолтынхоо нилээд хэсгийг хөдөөгийн хөдөлмөрчдөд зориулж 20 мянгад хүнд үйлчилж н а м, засгийн тогтоол шийдвэрийг таниулж, лекц яриа хийх, цаг үеийн үйл

явдлыг самбар, үзүүлэнгээр сурталчиллаа.

Мөн Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говьалтай, Хөвсгөл, Булган аймгийн сум, нэгдэл, САА, бригадаар орж 88 удаа тоглоонд 24 мянга гаруй хүнд үйлчилжээ гэж яриу.

Тус Соёлын ордны хамт олон ингэж ажилласнаар жилийн уран бүтээл ордны төлөвлөгөөг хоёр сарын өмнө 110,7—120 хувь биелүүлжээ.

Эднийхэн ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ийн нам, засгийн төлөөлөгчид манай оронд айлчлан ирэхтэй холбогдуулан уран бүтээлчдийн дунд 90 хоногийн уралдаан зарлаж туран бүтээл, соёл, олон түмний ажилдаа ам-

жилт гаргахаар шамдан ажиллаж байна.

Тус ордныхон Д.Дашзэвэг, Г.Чимэд нарын зохиол «Тулгын гурван уул» жүжиг болон «Миний нэр монгол» концерт найруулдан тоглож хүндэт зочид доо бэлэг барих аж.

Соёлын ордны хамт олон аймгийн Ардын театрт мэргэжлийн туслалцаа үзүүлж, одоо Галданжамцын зохиол «Улиастайн булан», Г.Цэндоржийн зохиол «Зорголын гүнж» зэрэг жүжгүүдийг тоглохоор бэлтгэв. Манай аймгийн төвийн дунд суугуулдтай шөфийн холбоо байгуулж 120 гаруй хүүхэдтэй «Солонго чуулга» байгуулан хүүхдийг бүжиг, хөгжмийн дугуйланд хичээллүүлж байна. Н. ПАНЖИД

НАЙРАМДАЛ—ДРУЖБА ҮЗЛЭГ

Саяхан Баянжаргалан сумын дунд сургуулийн захиргаа, бүлгэмийн зөвлөд сурдаг хөдөлмөрийн залгамж үеийн аяны «Найрамдал—дружба» гэсэн сэдэвт урлагийн үзлэгийг анги, бүлгүүдийн дунд явууллаа.

Урлагийн үзлэгээр ангийн бүлгүүдийн сургуулийн аварга дуучин, бүжигчин, уран уншигч, ерөөлч, магтаалчдыг шалгаруулахад 5,4,3-ын «А» ангид тэргүүн байр эзэлж 1 дүгээр ангийн сурагч О.Эрдэнэ-

бат, Наранцайрал, 2 дугаар ангийн сурагч Сайнзориг, Уранчимэг, Ц.Даваасүрэн, 3 дугаар ангийн О.Эрдэнэбилэг, Дүүрэн, Д.Дашдулам, С.Ганбаатар, Б.Ренчинханд, 4 дүгээр ангийн Наранхүү, Пүрэвдулам, Энхбаатар, Энхтуул, Сайнбуян, 5 дугаар ангийн Хишигсүрэн, Цэндсүрэн, Үүрцайх, Нармандам, Мянмар нар анги тус бүрийн аварга дуучин, шүлэгчин, бүжигчин, ерөөлч, магтаалч болов. Ж.БАНЭРАГЧ

НЭМЭЛТ ҮҮРЭГ АВАВ

Тээврийг удирдах газрын хамт олон ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Брежнев манай оронд айлчлан ирэх баярт өдрийг угтсан хөдөлмөрийн ээлжинд өндөр бүтээлийн болзолт уралдаан зарлаж ажиллан, авсан үүргээсээ авто тээвэрээр 72,3 мянган тонн километр, 87,0 мянган хүн километр, зам засвараар 40,0 мянга, бараа борлуулалтаар 20,0 мянган төгрөгийн ажлыг илүү хийж хүн тээврийн жилийн төлөвлөгөөг 122,9 хувь бараа татан авалтыг 105,6 хувь, бараа борлуулалтыг 109,7 хувиар биелүүлж, ачаа тээвэр, барилгын төлөвлөгөөг ордны хугацаанд биелүүлжээр шалдаж байна.

Тус газрын хамт олон энэ онд уралдаанд авсан үүргээсээ 170,0 мянган тонн километр, 200,0 мянган хүн километрийн ажлыг, нефть бараа борлуулалтаар 400,0 мянган төгрөг зам барилгаар 20,0 мянган төгрөгийн ажил илүү гүйцэтгэж түүхт ой болон хүндэт зочноо угтаа хаар нэмэлт үүрэг авлаа.

Одоо тус газрынхан нэмэлт үүрэг амдалтаа хэрэгжүүлэхээр шуурхайлан ажиллаж байна.



Аймгийн Барилга урсгалын нэгдүгээр сан—техникийн бригадын галчурчин Г.Бор V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 6 сарын өмнө 103 хувиар биелүүлж «V таван жилийн галчурчин» тэмдгээр санхүүг шалгаруулав.

ЗУРАГ ДЭЭР: Намын гишүүн Г.Бор ажил дээрээ.

Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг

Б.БААТАР

АЙМГИЙН НАМЫН ХОРООНД

Саяхан аймгийн Намын хорооны товчооны гишүүдийн өргөтгөсөн хурал Бүрэн сумын төвд болж «Мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг хэрхэн хангасан тухай тус сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Цэрэндоржийн илтгэлийг сонсч хэлэлцээд тодорхой заалт бүхий тогтоол гаргалаа.

Бүрэн сумын нам, захиргаа, ХАА-н байгууллагууд мал таргалуулах отор нүүдэл хийх талаар намын үүрийн бүх гишүүд, хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлж, зун намрын отор хийж, бэлчээрийн ургамлыг хамгаалах арга хэмжээ авсанаар сумын бүх малын 39,6 хувь нь дундаас дээш, 54,8 хувь нь дунд зэрэг тарга хүч авчээ. Тус сум энэ онд 8 хашаа шинээр барьж ердийн 14 худагт бүхээг дулаалга барьж нийтдээ 40 тонн усны багтаамжтай суурийн автомат ус-луур 9,7 г хийж, 100 гаруй мянган ширхэг зоодой бэлтгэжээ.

Мөн тэжээл—эмчилгээний тохилог цэг шинээр байгуулж ашиглалтанд оруулжээ.

Гэвч мал аж ахуйн өвлийн бэлтгэл 72 хувийн балтай байна.

Өвлийн бэлтгэл ажлын чухал хэсэг болсон хадлан бэлтгэх улсын төлөвгөө тус сум 34 хувиар тасалдуулсны гадна нийт суурийн 20 хувь нь саравчтай хашаагүй байгаа ба олон тооны сууриуд хашаа хороогоо засч дулаалах ажлыг бараг хийгээгүй өдий хүрчээ.

Нэг настай малыг 800-

1400 толгойгоор суурилан тэжээж арчлах ажлыг хангалтгүй хийж байна. Сумын нутаг өвс ургамлаар тачир, цаг, хүндрэхэд хүрвэл зудын аюулд орж болзошгүй байхад бэлчээрээ хамгаалж өвлийн бэлтгэлийг бүх талаар хангахын оронд одоо зарим суурь өвөлжөө, хаваржааны бэлчээрийг идүүлж байна.

Тус суманд малын тэжээл, хужир шүүний нөөц маш хангалтгүй байна.

Энэ нь сумын намын байгууллага удирдлагын сонгомол арга социалист уралдааныг цаг үеийн ээлжит зорилттой нягт холбон энэ ажилд нам, улс, олон нийтийн байгууллагын хүчийг дайчилж, хөдөлмөрчдийн улс төр хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэх явдлыг урсгалд нь орхиж, өдөр тутмын аар саархан асуудлаар хөөцөлдөж, цаг хугацаа алдсанд оршино гэж аймгийн Намын хорооны товчоо үзэв.

Аймгийн Намын хорооны товчооны хурлаас Бүрэн сумын намын үүр, АДХ-ын гүйцэтгэх захиргаанд даалгахдаа: Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн дутууг бүрэн хангах аж ахуй зохион байгуулалтын арга хэмжээг авч биелэлтийг 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Намын хороонд илтгэх.

Адуу, сувай үхрийн суурийн оторлох зураглал бэлтгэлийг сайн хийж 11 дүгээр сарын 15-ны дотор гаргах.

Нэг настай малыг МАХН-ын Төв Хороо, БНМА

У-ын Сайд нарын Зөвлөлийн 32-р тогтоолын дагуу цөөнөөр суурилож, хашир туршлагатай малчдад хариуцуулан малдуулах.

Дундаас доош тарга хүчтэй малыг 11 сарын 8-наас эхлэн ялган суурилож айл өрхөд цөөн цөөнөөр нь хариуцуулан тэжээлд оруулах.

Мал аж ахуйн бригадын хариуцлагатнуудыг 1974 оны 11 дүгээр сард багтаан нэг дор төлөрүүлэн буулгаж, тэдний ажил хариуцах хариуцлагыг нь сайжруулах, өвөлжөө хаваржаануудыг гүйцэд дулаалах, саравч пүнз засах ажлыг яаралтай хийлгэн шалгаж хүлээн авах, энэ ажилд олон нийтийн байгууллага, малчдыг өргөн оролцуулах.

Цаг хүндрэх нөхцөлд малын онд бүрэн оруулах онцгой арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллах, мал аж ахуйн сууриудыг хэсгийн системд шилжүүлэн социалист хөдөлмөрийн хөдөлгөөнтэй холбох ажлыг 1974—1976 онд багтааж дуусгах.

Тус хурлаас нийт сумдын хороо (үүр), АДХ-ын гүйцэтгэх захиргаанд даалгахдаа:

1974—1975 оны өвөл хавар мал сүргээ онд бүрэн оруулахын тулд сууриудыг ажиллах хүч, малчдыг ажлын дадлага туршлага, хариуцлага санаачлага, материаллаг баазар сайн, дунд, муу гэсэн үзүүлэлтээр дүгнэн дунд ба муу сууриудад онцгой анхаарал тавьж туслах, алсын оторт яваа малчдад өргөн хэрэгцээний

бараа, хүн мал эмнэлэг, ухуулгаар шуурхай үйлчилж байх зорилгоор оторчдод үйлчлэх штабыг 11 дүгээр сард багтаан байгуулж тодорхой төлөвлөгөөтэй ажиллуулах, төрөл бүрийн тэжээлээр мал тэжээх арга барил норм хэмжээ, журмыг мал аж ахуйн мэргэжилтэн нараар заалган эзэмшүүлэх, тэжээлийн хадгалалт хамгаалалтанд нарийн хяналт тавьж, зарцуулалтанд тооцоо хөтлөх, худалт дулаалга бүхээг барьсан, суурийн автомат услуурыг хийсэн Бүрэн сумын туршлагыг улам боловсронгуй болгож, 1975—1976 онд бүрэн нэвтрүүлэх. Тус хурлаас ХАА-н нэгдэл, САА-н тасаг, бригадын агентуудыг ердийн хөсөг тэргээр хангаж тэднээс малчдаар явж үйлчлэх ажлыг сайжруулахыг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХААУ газар, Тээврийг удирдах газар, ХБУ газарт үүрэг болголоо.

Ганцхан минутанд

ЗХУ-д одоо нэг минутанд 3 автомашин, 1 трактор, 12 ширхэг зурагт радио, 10 ширхэг хөргөгч, 18915 хавтгай дөрвөлжин метр нэхмэл, бараг 860 тонн нефть, 258 тонн гаруй болд, 1853 мянган квт цаг цахилгаан энерги, 217 тонн цемент гаргаж байна.

Мөн нэг минутанд 45 тонн илүү сүүн бүтээгдэхүүн, бараг 150 тонн минералын бордоо, 2690 ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлэж байна.

Баатар хоньчны туршлагаар

МАХН-ын гишүүн Гончигжамбаа Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдэл бригадын даргаар ажиллаж байгаад өнгөрсөн оны 12 дугаар сараас эхлэн өөрийн санааар малчин болж нэгдлээсээ 663 эр хурга, 183 ишиг хүлээн авч малажээ.

Гончигжамбаа 1972 онд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б.Ажвагийн арга туршлагатай очиж танилцаад хотгүй отор хийж мал таргалуулахаар зориг шулуудан ийнхүү малчин болжээ.

Ажилд махруу, нөр хичээнгүй энэ хүн санаснаа ажил болгохоор цуцалтгүй ажилласны үрээр өнгөрсөн оны өвөл хариуцсан хурга, ишгээ онд бүрэн мэнд оруулаад энэ жилийн зун намар хотгүй оторт гарсан байна.

Энэ жил тэрээр отрын жижиг гэр, авсаархан төхөөрөмж бэлтгэн оторт гарч 20 шахам удаа нутаг сэлгэн нүүдэл хийж малдаа сайн тарга хүч авахуулсны үрээр ноос, ноолуур, хялгасны үйлдвэрлэлийн даалгавраа цөм давуулан биелүүлжээ.

МАХН-ын гишүүн, хоньчин Гончигжамбаа МАХН-ын III их хурал хуралдсан, БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойг угтаж мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлээ бүрэн хангаад одоо мал сүргийнхээ таргыг тогтоож онд бүрэн мэнд оруулахаар чармайн ажиллаж байна.

Я. ДАМДИНСҮРЭН

ЭМЧИЛГЭЭ—ТЭЖЭЭЛИЙН ЦЭГ

Эмчилгээ-тэжээлийн цэг бол мал эмнэлгийн үйлчилгээг шуурхай болгон эмчилгээний үр дүнг дээшлүүлж, өвчилсөн мал нэг бүрийг эмчлэн эдгэрүүлэх нээр малын зүй бус хорондлыг нам, засгаас тавьж буй зорилтын хэмжээнд хүртэл багасгах, ядарч доройтсон малыг бордож төнхрүүлэн тарга хүнийг сайжруулах зэргээр махны нөөцийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой юм.

1974 оны эхний 3 улирлын байдлаар аймгийн хэмжээгээр зүй бус шалтгаанаар хорогдсон мал өнгөрсөн оны мөн үеэс 36,3 хувь буюу 16,8 мянгаар багасаж, төл бойжуулах улсын төлөвлөгөөг 10,9 хувиар давуулан, хагас сая шахам төл бойжуулж байгаа явдалд эмчилгээ тэжээлийн цэгүүд зохих үр дүнгээ өгч байгаа нь дамжиггүй юм.

Одоогийн байдлаар манай аймгийн нийт сумдад эмчилгээ-тэжээлийн улсын цэг байгуулагдан

энэхүү цэгүүд нь мэргэжлийн боловсон хүчин, багаж төхөөрөмжөөр бүрэн хангагдаж, аймгийн хэмжээгээр зөвхөн эмчилгээ тэжээлийн цэгийн үйлчилгээнд 20 гаруй авто машин ажиллаж байна.

1974 оны эхний 2 улирлын байдлаар эмчилгээ тэжээлийн цэгт бүгд 11,3 мянган мал хүлээн авснаас 60,4 хувийг эдгэрүүлжээ. Угтаал, Батсүмбэр, Дэлгэрхаан, Баянцогт, Өндөрширээт зэрэг нилээд сумдын эмчилгээ тэжээлийн цэгүүд 10—14 хоногт сууриудад графикаар 1—2 удаа явж өвчтэй малыг цэг дээр цуглуулан өвчний төрлөөр ялгаж, түүх хөтлөж эмчилгээ тэжээлийн чанарыг сайжруулах зэргээр цэгийг зааврын дагуу ажиллуулж байгаагаас эдгээр сумдын эмчилгээ-тэжээлийн цэгт 1973 онд цугларсан бүх малын 80-95 хувь, 1974 оны эхний 2 улиралд цугларсан малын 70—86 хувь нь эдгээр 7—15 мянган төгрө-

гийн ашигтай ажиллажээ.

Гэвч нийт эмчилгээ-тэжээлийн цэгүүдийн ажил жигд сайжирч чадаагүй, өвчтэй малыг зохих хугацаанд нь цуглуулахгүй, цугларсан малыг цаг тухайд нь бүрэн эмчлэхгүй, өвчний төрлөөр ялгахгүй, өвчний түүх болон цэг дээр хөтлөгдөх бүртгэл тооцоог ёсчлон хийдэггүй явдлууд гарсаар байна. Энэ мэтээр хангалтгүй ажиллаж байгаа эмчилгээ-тэжээлийн цэгийн тоонд Баянцагаан, Баянжаргалан, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баянзүрх сумдын эмчилгээ-тэжээлийн цэгийг дурьдаж болно.

Ийм байдалд дүгнэлт хийж эмчилгээ-тэжээлийн цэгийн ажиллах цагийн хуваарь, эмч, санитарч, малчдын үүрэг хариуцлагыг удирдамжийн дагуу тус тусын онцлог байдалд зохицуулан боловсруулж, уг үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байгааг сумын Намын хороо (үүр) АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ХАА-н

нэгдлийн зөвлөл, тэдгээрийн дэргэдэх АХШ хороо, групп, нэгдлийн ХБК-оос тухай бүрт нь шалгаж ажлыг эрчимжүүлэн хэвшүүлж цэг бүрийг жигд тогтмол байнгын ажиллагаатай болгох явдал чухал байна.

Энэ зорилтыг хангахын тулд энэ оны 11 дүгээр сард Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн эмчилгээ-тэжээлийн цэг дээр нийт сумдын мал эмнэлгийн салбарын ба эмчилгээ-тэжээлийн цэгийн эмч нарын үзүүлэх сургууль хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулж сум бүр өөрийн цэгийн ажиллагааг жигд тогтмол болгох талаар оновчтой ажил зохиох хэрэгтэй.

Сумын эмчилгээ-тэжээлийн цэгээс бригад сууриар сард 2-оос доошгүй удаа явж өвчтэй, ядарч доройтсон малыг цэгт цуглуулан чанартай эмчилснээр малын зүй бусын хорондлыг багасгаж, суурь дээр мал үхэх явдлыг бүр мөсөн зогсоож болох юм.

Эмчилгээ-тэжээлийн цэг дээр ирсэн малыг нэг-

бүрчлэн ерөнхий журмалд бүртгэхийн дараа мал бүр дээр өвчний түүх нээж өдөр тутам эмчилж хийгдсэн эмчилгээг уг түүх дээр нь нэг бүрчлэн бичиж байх ёстой.

Цэг дээр байгаа хүнд өвчтэй босч явж чадаагүй малыг эмчлэхийн зэрэгцээ байнгын өвс тэжээл, ус, хужир тавьж өгч байвал зохино.

Харин энэ ажил тэр бүр хийгдэхгүй байгаагаас өвчтэй мал усаар дутаж үхэх явдал байна.

Эмчилгээ-тэжээлийн цэгийн машины ашиглалтыг эрс сайжруулж, үргүй зардал гарган шатахуун тос, тн/км-ийн тооцоогүй байдаг дутагдлыг даруй засвал зохино.

Цэг дээр үхсэн малын мах, арьс зэрэг бүх бүтээгдэхүүнийг бүрэн ашиглах, цугларсан малын эд гэрэлтийн хувийг ахиулах, эм тэжээл, шатахуун тосыг хэмнэлтэй, нягт ням бай зарцуулах замаар эмчилгээ-тэжээлийн цэгийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх явдал шаардагдаж байна.

М. НЯМАА

Нийслэлийн ойд уригдан оролцсон зочин ЯМАА МАЛЛАХ САЙХАН



сүргийг яаж маллавал ашигтай вэ? гэж асуусан байдаг.

Намын гишүүн Б. Лхам үүнд баттай хариу өгөх туршлагаар 1968 оноос эхлэн Ангар үүлдрийн ямаа хариуцан малласан бүх л хугацаандаа уулын бартаа дамжиж ургамлын шинг хөөсөн ямаан сүргийн хээ бэлчээрт хуримтлуулсан хүн.

Хүн болгоны сонирхдог нөгөө асуултыг тавихад минь тэр Цээл, Хайрхан хаа ууланд бэлчиж - яваа хагас мянган ямаан сүргийнхээ барааг харсан адил сэтгэл нь улам ч баклй болоод ийн ярьсан юм.

—Манай нутагч сайхан.

Ямаа маллах ч сайхан. Тэгэхдээ ализ ажилд аргы нь олох гэж байдаг шүү дээ гээд арвин туршлагаасаа ярьв.

Ямаан сүрэг нь малч эзнийхээ ухаан, барьсан шилбүүрийнх нь зөөлөн гишгэлтээр жилийн дөрвөн улирал—дөрвөн янзын маллагаанд үржин өсч өөхлөн таргалсаар иржээ.

Эдний суурь өнөө жил 500 ангар ямаанаас 500 нийг бойжуулж сүү ноолуур зэрэг бусад төлөвлөгөөт даалгавраа 100—

МЭМДЭГЭЛЭЛ

110 хувиар биедүүлсэн аж. —Ямааг хоньтой хамт хариулахад бэлчээрээ голж тогтвортой идэшилж чаддаггүй.

Иймээс дангаар нь жилийн аль ч улиралд уулархаг нутагт, өвөл нь бол нөмөр сархиаг, сөл сайтай, зун сэрүүвтэр газар бэлчээх нь ашигтай.

Ус голомттой байдаг болохоор шүвтэр шалбааг гүй цэнгэр тунгалаг усаар услаж, байнга хужирлаж соргог шинэ нутаг сольж байвал амархан таргалдаг мал даа.

Би, хөдөлмөрийн баатар Б. Ажваа багшийнхаа туршлагаар отор хийдэг бөгөөд одоо 26 дахь буудал дээрээ буугаад байгаа гэв.

Баатрын шавь өөрөө бас олон залуу шавьтай хүн юм.

Түүний шавь, илгээлтийн эзэн, хоньчин Халтар МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын заалтаас давуулан төл бойжуулж сумынхаа залуу малчдыг уралдаанд мандалж яваа аж.

Б. Лхам гурван шавиа тэргүүний малчны зэрэгт хүргэх гэж ихийг бодож хийдэг хүн болох нь түү-

ний ярианаас илэрхий байв.

—Ямаачны хөдөлмөр намайг аз жаргалд хүргэж аймгийн аварга гэдэг хүндэт алдар хүртээж би хангалуун сайхан амьдарч байна. Тэгээд ч би энэ хөдөлмөрийнхөө үр шимээр Улаанбаатар хотыг БНМАУ-ын нийслэлээр тунхагласны 50 жилийн их ойн баяр ёслолд оролцлоо. Энэ үеэр Сүхбаатар, Чойбалсангийн бунхан, Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөлдөж, баярын хуралд сууж, концерт, улсын цирк зэрэг олон сайхан үзвэр үзэж архи пивоны үйлдвэрээр орж эх орныхоо нийслэлийн социалист хөгжилтэй танилцаад нам, засгийнхаа ач гавьяаг бахдаж хөдөлмөрийн хүмүүсийн суу гайхамшигт биширч явлаа.

Жирийн нэгэн ямаачин би энэ их ойн баярт оролцож нам засгийнхаа удирдагчид, гадаадаас ирсэн хүндэт зочидтой уулзан ярилцаж мөр зэрэгцэн суусан маань манай эх оронд хөдөлмөрийн хүн хичнээн хүндтэй байдгийн баталгаа юм гэж өөрийн сэтгэгдлээ догдлон ярьсан юм.

Манай сурвалжлагч Ш. ЦЭРЭНДОО

ӨНТЭЙ ӨВӨЛЖИЖ БАЙНА

Сүмбэр уулын оргил улбар шар наранд цайвартан бууралтаж, түүний бэлээр малчны цагаан гэрүүд танан товч мэт ярайн өвөлжөөлжээ.

Бидний хамт явсан Батсүмбэр сум—САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Г. Хаянхярваа:

—Манай САА-н малчид саальчид энэ дээ.

Эд, их ойнуудаа угтаж МАА-н өвлийн бэлтгэлийг халуун намраар хангаад өвлийнхөө бэлтгэлийг хүлээлгэж өгөхөд жин тан болоод байна гэв.

Батсүмбэрийн САА-н саальчид Завхан аймгийн Сантмаргац сумын туршлагаар өвөлжөөнөөс гархдаа хашаа пүнээ шаврандан засаж сэлбээд буудаа хүрэлцэх хэмжээгээр татан, био тээрмийн аргаар ариутган намар өвс тэжээлээ татаж өвлийн бэлтгэлээ хангадаг болжээ.

Саалийн 6 бригад тус бүр нь 10—20 нуруу өвс, 10 шахам тонн дарш, 8—10 тонн бууц, 5—8 тонн хужир шүү базаан, булаг шандаа засчээ.

Хөдөөгийн Гүнжилам, БНМАУ-ын аварга малчин Ц. Хорлоо ярихдаа: —Саальчид өөрсдийн хүчээр өвлийнхөө бэлтгэлийг ханган, одоо өвөл цагийн хүмүүжлийн ажилдаа ороод байна.

Энэ маань их ойнууд болон ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийг айлчилан ирэх хөдөлмөрийн ээлжинд оруулж буй бас нэг хувь нэмэр юм гэв.

Ингэж Сүмбэр нутгийн хан энэ оны өвөл өнтэй тарган өвөлжих гэж байна.

Д. ДУЛАМЖАВ

УХУУЛГЫН МОРИН БРИГАД

Саяхан Алтанбулаг сумын намын үүр ухуулгын морин бригадуудыг суамсаа алс хол байгаа мал аж ахуйн суурь, бригадал гарган үйлчлүүлэв.

Ухуулагч Жагварал ахлагчтай ухуулгын морин бригад сумаас 90 км алс байгаа хонины суурь, бригадаар 7 хоног аялж 50 гаруй сууриар орж, олон зуун хүмүүст Лениний одонт Курган муж, нэг наст малгыг онд сайн оруулж, ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийг их амжилтаар угтъя гэх зэрэг сэдвээр ухуулга яриа хийсний дээр суурийн хүмүүжлийн ажилд туслан туршлага судалж, урлагийн тоглолт хийжээ. Энэ ажилд МАХН-ын гишүүн Тунгалаг, Маруся, Дэнсмаа наридахтай оролцов.

Ш. ДИНАМ

ЗХУ-ЫН ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛТ

ЗХУ-ын хөнгөн аж үйлдвэр, Зөвлөлтийн улс ардын аж ахуйн томоохон салбарын нэг бөгөөд одоогоор тус орны бүх аж үйлдвэрийн бүтээгдээгүй тавны нэгийг үйлдвэрлэж байна.

ЗХУ-ын хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжилт нь үйлдвэрийн бүхий л салбар, түүний дотор хөнгөн аж үйлдвэрийг тууштай хөгжүүлэх техникийн бааз суурийг бий болгож, хөнгөн аж үйлдвэр өөрийн оронд үйлдвэрлэгдсэн машин төхөөрөмжөөр тоноглогджээ.

1960-аад он бол ЗХУ-ын хөнгөн аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийн жилүүд бөгөөд үйлдвэрлэлд механикжилт, автоматжилт өргөнөөр нэвтэрч автомат удирдлага бүхий урсгал шугам дамжлагууд буй болжээ.

1959—1965 онд нэхмэлийн үйлдвэрүүдэд самнан тууз үйлдвэрлэх хагас автомат удирдлага бүхий урсгалшугам, автомат ажиллагаа бүхий нэхэх машин, олон булт хээ тавих машин, тасралтгүй ажиллагаат найруулах агрегат зэрэг дэвшилтэт техник тоног төхөөрөмж нэвтэрсэн байна.

Олон арван үйлдвэрийн газар шинээр байгуулагдаж, үйлдвэрлэлийн техник технологийн түвшин дээшлэн, автоматжилт, химижилт өргөн нэвтэрсэ-

нээр 1965 онд хөвөн даавуу үйлдвэрлэл 1913 оны хоос 3 дахин, ноосон болон олсон даавуу үйлдвэрлэл 4—5 дахин, торго үйлдвэрлэлт бараг 26 дахин өсчээ.

Арьс шир гутлын аж үйлдвэр эрчимтэй хөгжиж ихэнх арьс ширний үйлдвэрүүдэд механикжсан урсгалшугамууд нэвтрэн бүх гутлын үйлдвэрийн 90 гаруй хувь нь гутлыг дэвшилтэт арга конвейрийн системээр үйлдвэрлэх болсон байна.

Оёдлын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ эрс нэмэгдэж нэр төрөл нь олшров.

1965 онд ЗХУ-д 1.5 сая ажилчин бүхий 2000-аад оёдлын үйлдвэр ажиллаж байлаа.

Үйлдвэрлэлийн ажиллагааг иж бүрэн автоматжуулах, механикжуулах ажлыг эрчимтэй өрнүүлснээр үйлдвэрлэлийн нийгмийн үр ашиг дээшлэн, бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж эрс сайжирсан байна.

1959—1965 онд 50 томоохон үйлдвэрийн газар ашиглалтанд орж байсан бол VIII таван жилд 360 гаруй үйлдвэрийн газар ашиглалтанд орж хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал бараг 2 дахин нэмэгджээ.

1970 оны байдлаар хөнгөн аж үйлдвэрийн бүх үйлдвэрүүд, ихэнх сал-

бар эрхэлсэн удирдах газрууд төлөвлөлт эдийн засгийн урамшууллын шинэ системд шилжин орсон байна.

ЗХУ-ын хөнгөн аж үйлдвэр 30 гаруй биеэ даасан салбараас бүрдэж байгаа бөгөөд нийтдээ 4 сая орчим ажилчид, ИТА-тай 3100-гаад нэгдэл биеэ даасан үйлдвэрийн газруудыг хамарч байна.

IX таван жилийн төлөвлөгөөний эхний гурван жилд 120 комбинат, фабрик, 600 цех тасгийг иж бүрэн механикжуулан хөнгөн аж үйлдвэрийн хэмжээгээр 5 жилийн эхний гурван жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. 1971—1973 онд нэхмэлийн үйлдвэрүүдэд химижүүлэлт өргөнөөр нэвтрэн химийн мяндасны хольц бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлт эрс нэмэгдэж полиамид, пропилений эзлэхүүн бүхий ээрмэл, таталтаар хэзэгдэх даавуу, сөвсгөр резинэн ултай гутал зэрэг химийн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт амжилтуудыг тусгасан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Шинэ таван жилийн эхний 3 жилд Чита, Черногорин нэхмэлийн комбинат, Блгочевсенекийн ээрэх үйлдвэр, Пинскийн сүлжмэлийн үйлдвэр зэрэг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон

асар том үйлдвэр аж ахуйн газрууд ашиглалтанд орж нийтдээ 780 мянган ээрүүл, 17 мянган нэхэх машин, олон арван оёдол, гутлын тоног төхөөрөмж шинээр суурилагджээ.

IX таван жилийн төлөвлөгөөний шийдвэрлэх жил—1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг хөнгөн аж үйлдвэрийн хэмжээгээр 102 хувиар биелүүлжээ.

Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаар авч явуулсан олон талт арга хэмжээнүүдийн үр дүнд хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар эрс дээшлэн IX таван жилийн эхний 3 жилд 4,0 сая гаруй бүтээгдэхүүн чанарын тэмдэг авсан байна.

ЗХУ-д хөнгөн аж үйлдвэр, өндөр мэргэжлийн боловсон хүчин бүхий маш хүчирхэг эрдэм шинжилгээний баазтай юм.

Хөнгөн аж үйлдвэрт 35 орчим эрдэм шинжилгээний салбар институт, 80 орчим зохион бүтээх ба зураг төсвийн товчоо, 100 гаруй үйлдвэрлэлийн туршлага шинжилгээний лаборатори ажиллаж, нийт дээ 20 мянга гаруй эрдэм шинжилгээний ажилтан туршлагатай инженерүүдийг хамарч байна.

(Төгсгөл нь IV дүүрт)

СҮР ЖАВХЛАНТ АЯЛГУУ

Баярын амралтын өдөрүүд Зуунмод хотод хамгийн их цэнгэл хөгжилтэй байлаа.

Хүн бүхний нүүрэнд аугаа их Октябрийн баярын баясал мишээлт тодорч гоёлын хувцсаа өмсөсөн олон зуун хүмүүс Соёлын ордон руу алчлала. Энэ алхалт жирийн бодовч учиртай.

Аймгийн Соёлын ордны тайзнаа гал улаан хилэн хөшиг алгуурхан нээгдэхүй, сүр жавхлант аялгуу чихнээ сонсдон хөгжмийн хэлээр ярьж эхэллээ. Оросын сонгодог хөгжмийн зохиолч П. Чайковскийн IV симфони, финал (танго) Германы сонгодог хөгжмийн зохиолч Л. Бетховений «Эгмонт» монголын нэрт зохиолч Л. Мөрдоржийн «Эрийн гурван наадам» зохиол болон Ц. Намс-

райжавын «Баярын жавхлант» Р. Чойдогийн «Улаанбаатарын өглөө» зэрэг зохиолыг симфони тоглоов. Хөгжмийн удирдаачтерийн шагналт, БНМАУ-ын гавьяат жүжигчин Ц. Намсрайжав, туслах удирдаач Жигжидсүрэн нар хөгжмийн хүрээлэнгийн бүхий л чуулгыг уран чадамгай удирдаж байгаад сонсогч олон халуун талархлаа байн байн дэвшүүлж байв.

Мөн аймгийн АДХГ захиргааны соёлын хэлтсийн зааварлагч Содномхүү симфони, дан хөгжмийн тоглолтонд Кармен дуурийн оршил, ардын хоёр дууны найруулгыг удирдаж мэргэжлээрээ өсч яваагаа харуулав.

Ингэж «Баян монголы», «Соёл эрдэнэ», Симфони хөгжмийн чуулгуудын тайлан тоглолт үзэгч ол-

ны халуун талархлыг хүлээлээ. Ялангуяа БНМАУ-ын гавьяат жүжигчин Оросоо, Загнад, хөгжмийн залуу зохиолч удирдаач Наранбаатар нарын хувийн номерууд үзэгчдэд нэн их таалагдаж байв.

Улсын симфони 1958 онд, Баян монгол чуулга 1967 онд, Соёл эрдэнэ чуулга 1971 онд анхны тоглолтоо хийж эхэлсэн хойш төдий удаагүй боловч улсын филармони болтлоо өсөн хөгжиж ирсэн нь манай хөгжмийн анти төрөл, ур чадвар хичнээн их өндөр соёлтой болж байгаагийн баримт мөн.

Улсын филармоний сүр жавхлант аялгуу, социалист монгол орныхоо хөгжил бадрал, хөдөлмөр амьдралыг магтан дуулж байна.

П. ОЧИРБАТ

ЭМНЭЛГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД САНАМЖ

Эмнэлгээр үйлчлүүлэгчид юуны өмнө уг байгууллагын дүрмийн шаардлага, ариун цэврийг сахих, үйлчилгээний дэглэм журмыг биелүүлэхэд анхаарах ёстой.

Эмнэлгт очихын өмнө усанд орж дотуур хувцасаа сольсон, үсээ угааж засуулсан, хумсаа авсан байхаас эхлэн наадзахын шаардлагуудыг хангах, хэрвээ эмчийг дуудуулж үзүүлэхээр бол дээрх шаардлагыг гүйцэтгэсэн байхаас гадна гэр орныхоо ариун цэврийг улам сайжруулж, эмчийн гарыг ариутган цэвэрлэх ариутгалын бодис, саван, цэвэр алчуурыг бэлтгэсэн байх нь зүйтэй.

Эмнэлгт хэвтэж буй өвчтөн тасаг өрөөндөө цэвэр байх, ор дөрний хэрэглээг үзэмжтэй хураас өрөө тасалгаандаа агаар тогтмол оруулж элдэв шуугиан гаргахгүй байх нь эмнэлгийн үйлчилгээг хөнгөвчлөн сайжруулахад тусалж байгаа хэрэг.

Түүнчлэн түргэн тусламжийг ялхгүй зүйлд дуудахгүй байж, яаралтай дуудлаганд хөнгөн шуур-

хай үйлчлэх боломжийг нэмэгдүүлж туслах нь чухал юм.

Нөгөө талаар хэвтэж эмчлүүлэгчид ялангуяа өвчтэй хүүхдээ эмнэлгт асарч сувилуулахдаа зарим эцэг эхчүүд дур зоригороо авирлан эмчийн өгсөн зөвлөлтөө санамжийг зөрчин хориглосон эм тариа, хоол унд өгч хүндрүүлэх явдал үзэгддэг. Ер нь өвчтөн хүнтэй ярихдаа болгоомжтой сэтгэлд нь сөв суулгахгүй байх нь маш чухал. Ялангуяа удаан хугацаагаар өвчинд нэрвэгдсэн хүн их өөнтөгч, хэн юу ярьж байгааг маш сорогоор тусган авч өөрийн бие мах бодид дахвар шаналгаа нэмдгийг бодох ёстой. Өвчтөний дэргэд энэ эмч муу тэр нь сайн энэ эм тусгүй гэх зэрэг сул яриа ярих нь өвчнөөс

ангирхах эдгэрэхэд муугаар нөлөөлдөг. Өвчтөн хүний ойр дотны хүмүүс нөхрөө эдгэнэ гэдэг бат итгэлийг төрүүлэх, нөхрөөсг чанараар асран туслах нь эмчилгээнд сайн нөлөө үзүүлнэ.

Зарим хүн өвчтнийг эргэж ирэхдээ заавал чанасан тарган мах, хар шөл, бууз, хушуур, сүүтэй өргөн цай төрүүтнийг ойр ойрхон өгөхийг урьдал болгодог. Харин өвчтнийг эргэхдээ амьд цэцгийн баглаа, сэтгэл сэргээх урам зориг нэмэх уран зургийн хувилбар, цинэ сонин сэтгүүл ном, түргэн эдгэрэхийг хүсч өрсөөсөн зурвас захидал өгөх, хоол ундын зүйлээс жимс ногоо, хөнгөн зууш амтлаг ундаа өгөх зэрэг нь бие сэтгэлийг сэргээх ач тус үзүүлнэ.

Н. НАНЖИД

Монголын тухай шивэ ном

Монголын ард түмний түүхийн тэмдэглэлт өдөр-БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойд зориулж Зөвлөлийн «Наука» хэвлэлийн газар «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» гэдэг нэг сэдэвт ном хэвлэснийг номын дэлгүүрүүд худалдаж байна. Уг номыг Т. А. Якимовичийн удирдлагаар хэдэн хүн хамтран бичсэн бөгөөд ерөнхий редактор нь Е. П. Ваврин юм.

Арван нэгдүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Төвийн нутгаар. Сарын дундаж агаарын температур 6-10 градус хүйтэн буюу хэвийн хэмжээнээсээ 2-5 градусаар дулаан. Сар шинийн эхээр шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус, зарим газраар 8-10 градус хүртэл дулаарна. 5-10-нд шөнөдөө 22-27 градус, өдөртөө 12-17 градус хүйтрэнэ.

Сарын хоёрдугаар арванхоногийн эх, 22-24-ний үе ба сарын сүүлчээр хүйтний эрч бага зэрэг суларч шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан байна.

Сарын бусад бүх хугацаанд шөнөдөө 18-23 градус, өдөртөө 5-10 градус хүйтрэнэ.

Хэвийн хэмжээнээсээ

бага, зарим газраар хэвлийн хэмжээний орчим 1-6 мм цас орно.

Сар шинийн хоёрдугаар арванхоногийн эхэн, гуравдугаар арванхоногийн дунд үеэр сонгидмоол үүдтэй. Зарим газраар бага зэрэг цас орно. Сарын бусад бүх хугацаанд бага зэргийн үүдтэй, цас орохгүй, салхи баруунаас секундэд 5-10 метр, сарын дунд үе болон гу-

ЗХУ-ЫН ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛТ

Төгсгөл. (Түрүүч нь III нүүрт)

Эдгээр эрдэм шинжилгээний институт сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт техник технологи боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлсний дотор оёдол, сүлжмэл, сүлжмэлийн өндөр бүтээлт хагас автомат урсгал шугамууд, мяндас, даавуу будагч хатаах, тооцоолон бодох машинт удирдлага, бүхий технологийн дамжлагат цацраг идэвхт туяаны тусламжтайгаар технологийн ажиллагааг хянах тө-

хөөрөмж зэрэг шинжлэх ухаан техникийн хамгийн сүүлийн үеийн нээлтийг хэрэглэж байна.

IX таван жилийн эхний гурван жил хагаст хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэйгээр зохион байгуулах 50-иад том арга хэмжээг үйлдвэрлэлд нэвтрүүлжээ.

ЗХУ-ын хөнгөн аж үйлдвэрийн хамт олон, ард түмнийхээ өсөн нэмэгдэж буй материаллаг болон соёлын хэрэгцээг бүрэн хангахад асар их үүрэг гүйцэтгэж байна.

Д. ДЭМБЭРЭЛДАШ
Б. ЦЭРЭНДАШ

МЭРЭГИЙН САНДУЙ

Аймгийн Намын хорооны ажилтан, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний аймгийн зөвлөлийн тэргүүлэгч Мэргэийн Сандуй албан үүргээ гүйцэтгэж байгаад зуурдаар нас барлаа.

М. Сандуй 1916 онд Увс аймгийн Завхан сумын нутагт төрсөн, 1943 онд МАХН-д гишүүнээр элсээ.

М. Сандуй нь 1939 оноос Нисэх хүчний албанд дунд тушаалын дарга, 1949 оноос Увс аймгийн Намын хороонд зааварлагч, хэлтсийн туслах, Хоршоодын холбоонд зохион зааварлах хэлтсийн эрхлэгч, 1955 оноос Байдрагийн САА-д Намын Төв Хорооны зохион байгуулагч, 1958 оноос Төв аймгийн Баянцагаан, Баянбараат зэрэг сумдад намын үүрийн нарийн бичгийн дарга, 1961 оноос аймгийн сонин газарт, 1962 оноос аймгийн Намын хороонд хариуцлагатай ажлуудыг үр бүтээлтэй хийж байв.

М. Сандуй нь 1955 онд Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд суралцаж төгссөн, онол улс төрийн өндөр боловсролтой, намын үзэл суртлын дайчин байлдагч, туршлагатай суртал нэвтрүүлэгч байлаа. Улсаас түүний гавьяа зүтгэлийг өндөрөөр үнэлж Алтан гадас олон болон бусад медалиудаар шагнажээ.

М. Сандуй 1955, 1957, 1959 онуудад Завхан, Баянхонгор, Төв аймгуудад Намын хорооны бүгд хурлын гишүүнээр сонгогдож байв. Мэргэийн Сандуйн ажилсаг хичээнгүй, энгийн даруу, шударга үнэнч зан чанар нь бидний сэтгэл зүрхэнд үүрд мөнх үлдэх болно. Талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсдөд гүн эмгэнэлээ илэрхийлэе.

Аймгийн Намын хорооны хамт олон, ХТАЗ-ийн аймгийн зөвлөлийн тэргүүлэгчид

Холбооны ажил хойрго байж болохгүй

Утсаар ярих, цахилгаан явуулах гэж холбоон дээр хэдэн өдөр дараалан очиж олон цаг суугаад ярьж харилцаж чадахгүй байх явдал Батсүмбэр, Заамар сумынханд тохиолдож боллоо. Түүгээр ч барахгүй энэ сумдын холбооны салбарууд захиалын дугуй, маркаар тасрах явдал ч бай

на. Мөн зарим үед хэвлэл дутуу ирж захиалагчдыг хохироож байна.

Энэ байдалд дүгнэлт хийж дээрх сумдын холбооны салбарын ажлын доголалдыг засах талаар аймгийн Холбооны газар анхаарах цаг болсон шуу!

Т. МУШАА

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б. ЦЭРЭНДАШ

равдугаар арав хоногийн дундуур салхи секундэд 12-15 метр хүртэл ширүүсч зарим газраар цасан шуурга шуурна.

Цаг агаарын урьдчилсан мэдээнээс үзвэл: Энэ сард бараг бүх нутгаар хэвийн хэмжээнээсээ 1,7-4,4 градус дулаан байх боловч төвийн нутгийн зүүн талын зарим хэсгээр хэвийн хэмжээнээсээ хүйтэн байна.

Сарын эхээр баруун зүгийн ба төвийн нутгаар

хүйтэн байна.

Сарын эцсээр баруун зүгийн ба төвийн зарим хэсэгт өдөрт 3 градус дулаан. Манай орны өвлийн эхэн үеэр цаг агаарын нөхцөлд онцлог өөрчлөлтүүд гарч их цас орох, хүйтний эрч цочрон чангарах явдал гардаг.

Иймээс манай малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүд өвлийн бэлтгэлийг сайн хангах хэрэгтэй юм.

Аймгийн Ус, Цаг уурын товчоо